

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**ЭЗЭН, БООЛЫН НИЙГЭМТ ЭРТНИЙ ХЯТАД УЛС
(М.Э.Ө. XXI—М.Э. III ЗУУН)****Н. Ишжамц**

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Хүн төрөлхтөн чулуун зэвсгийн үе, хүй нэгдлийн байгуулалыг туулж өнгөрөөд хүрэл, төмрийн үеэс эхлэн ангит нийгэм, төр улс, иргэншилт соёлтой болж хөгжсөн юм. Анхны ангит нийгэм, төр улс, иргэншилт соёл нь боол эзэмших ёсонд тулгуурлан гарч ирсэн байна. МЭӨ IV—III мянганы үед эртний Египет, Шүмер, Вавилонд эзэн боолын нийгэм, боол эзэмшигчдийн төр, зураг бичиг үүссэн байна.¹ Дараа нь МЭӨ III мянганы үед Энэтхэг, Газар дундын тэнгисийн Крит арал, Грекийн Микен нутагт боол эзэмших ёсны нийгэм, төр улс, үет үсэг бүхий иргэншилт соёл үүссэн байна. МЭӨ III мянганы эцэс, II мянганы эхээр Египет, Энэтхэг, Крит-Микенд нэгэнт гийгүүлэгчээр үг бүтээн тэмдэглэдэг цагаан толгойн үсэг бүхий бичиг үүсээд байв. Ялангуяа МЭӨ II мянганы үеийн Финикийн цагаан толгой үсэг дэлхийн олон улсад дэлгэрч маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм.² Чухам тэрхүү бичиг цаашдаа Арамей, Уйгураар дамжин Монголд нэвтрэн дэлгэрсэн нь бид бүхний мэдэх хуучин уйгуржин бичиг даруй мөн байв.

МЭӨ III мянганы эцэс—II мянганы эхээр Хятадад бас эзэн, боолын ёст ангит нийгэм, төр улс, дүрс үсэг бүхий иргэншилт соёл бий болсон байна. Хятад орон бол ангит нийгэм, төр улс, иргэншилт соёл эрт дээр үед үүсэн бүрэлдсэн орны нэг мөн бөгөөд тэр нь хятадын ард түмний бүтээлч шургуу хөдөлмөр, баатарлаг тэмцэл, оюун билгийн үр дүн юм. Гэвч дээрх баримтаас үзэхэд Хятадыг дэлхийн хамгийн эртний, хамгийн өндөр соёлтой цорын ганц улс— «Ертөнцийн төв»³ байсан мэт үздэг маоизмын номлол түүхэн үнэнд харшилж байгаа нь илт ажээ.

Эртний Хятад орон, хятад улс, хятадын ард түмэн, түүний амьдрал байдал чухам ямар байв, яагаад тэнд эзэн, боолын нийгэм бий болж, хэрхэн яаж хөгжиж байв гэдэг асуудал түүхийн шинжлэх ухаан, нанхиад судлал нэлээд тодорхой хариулт өгөөд байна. Хятад орон бол эрт дээр үеэс газар тариалан эрхэлсэн сууршмал орон байсаар ирсэн юм. Шар мөрөн хэмээх Хатан голын дунд урсгал дагуу, одоогийн Хятадын Хэнань, Шаньси мужийн нутагт МЭӨ III мянганы үед Ся, Шан, Чжоу гэх мэтийн хэд хэдэн томоохон хятад хэлтэн аймаг оршин амьдарч байсан бөгөөд нийтдээ 100 орчим овог болж хуваагдан байв. III мянганы дэд хагасын хятадад зэс, хүрлийн үйлдвэрлэл хөгжиж, газар тариалан, гар урлалд ахиц гараад

¹ История древнего мира, ранняя древность, М. 1982, с. 36, 54, 96—97.

² Всемирная история. Т. 1, М., 1955, с. 390—391.

³ Owen Lattimore, Inner Asian Frontiers of China, New York, 1951, P. 4

овгийн хүй нэгдлийн байгуулал задарч байжээ. Тухайн үеийн хятад овог, аймгуудын зонхилогч, сурвалжит язгууртан нар нийгмийн баялгийн нэлээд хэсгийг эзэмшиж ихээхэн хүч нөлөөтэй болж байв. Тэд өвөр хоорондоо хэсэг хэсгээр нэгдсэн аймгийн холбоо байгуулж, нэг нэгний эсрэг ба зэргэлдээх бусад овог, аймгийн эсрэг довтлон, олон хүн олзолж боол шивэгчин болох, эд хөрөнгийг булаан дээрэмдэх болж байв. Хүчирхэг аймгийн холбооны зонхилогч, сурвалжит язгууртны эрх мэдэл нэн их болж, овог, аймгийн гишүүдийн тэгш эрх, чөлөөтэй байдал аажмаар хумигдан байв.

III мянганы сүүлчийн хэдэн зуун жилийн дотор Хятадад өрх гэр, өмчит хөрөнгө үүсч, улмаар баян, ядуугийн ялгаа гарч, анги давхраа ялгарах үйл явц явагдаж байв. Овгийн хүй нэгдлийн ор суурийг эзэлсэн хөршийн хүй нэгдлийн гишүүдийн нэгэн хэсэг нь аймгийн зонхилогч, сурвалжит язгууртны зэрэг боол эзэмшигч дарлан мөлжигч анги, нөгөө нэг хэсэг буюу дийлэнх нь боолчууд, ядуус, дунд чинээний тариачид, гар урчуудаас бүрдсэн, дарлагдан мөлжигдөгч хөдөлмөрчдийн ангиуд болж хуваагдах чиглэлээр хөгжиж байв. Тухайн үеийн Хятадын нийгэмд хөршийн хүй нэгдлийн тариачид тооны хувьд дийлэнх ихэнх нь хэвээр үлдэж, аж ахуй эдийн засагт зонхилох байр суурь эзэлж байсан боловч боолчууд ба боол эзэмшигчид нь нийгмийн амьдралд зонилсон, эсрэг тэсрэг үндсэн хоёр анги болох тийш эргэлтгүй хандсан байна. Үүсэн бүрэлдэж байсан тэр хоёр ангийн хоорондын харилцаа, тэдгээрийн хоорондох ангийн тэмцэл нь нийгмийн амьдрал, хөгжлийн агуулга, шинж чанар, чиглэл явцыг шийдвэрлэх болж иржээ. Үүний улмаас эртний Хятадад боол эзэмших ёсны ангит нийгэм, төр улс, иргэншилт соёл үүсэн гарах явдал зайлшгүй болсон юм.⁴

Тухайн үеийн Хятадын үйлдвэрлэх хүчний хөгжил, эдийн засаг, аж ахуйд мэдэгдэхүйц ахиц гарч, гар урлал газар тариалангаас тусгаарлан салж, хот хөдөөгийн ялгаа гарч байв. Өндөр зузаан бат бэх цайз хэрмээр хүрээлэгдсэн хот суурингууд бий болсон нь хүчирхэг аймгийн холбооны зонхилогч, боол эзэмшигч сурвалжит язгууртны өргөө ордон орших төв газар болж байв. МЭӨ XXI зууны эхэн, дунд үеийн Хятад аймгуудын холбооны гол зонхилогч нь Юй гэдэг ихээхэн хүч нөлөө бүхий сурвалжит язгууртан байсан бөгөөд түүний өргөө ордон Хэнань мужийн умард хэсгийн Яньчжай хотод байжээ. Юй сэрүүн тунгалаг ахуй цагтаа уламжлалт заншил ёсоор сурвалжит язгууртны зөвлөл хийлгэж, өөрийн хойчийг залгамжлагчийг сонгуулж, нэр заалган тогтоолгосон байв. Гэтэл тэр сонгогдсон залгамжлагч нь МЭӨ XXI зууны 30-аад оны үест Юйг нас барсны дараа түүний ор суурийг залгамжилж чадсангүй, хэрэг явдал урьдынхаас ихэд өөрөөр эргэсэн байна.

Тухайлбал, Юйгийн ахмад хөвгүүн Ци өөрийн эцгийн залгамжлагчийг огоорон зайлуулж, эцгийн хойчийг шууд өвлөн залгамжилсан байна. Тэгээд Ци МЭӨ 2033 онд Яньчжай хотын орчин дахь Юйсянь хотын умард хаалгын гадна Цзюньтай хэмээх газарт бүх хятад аймаг, овгуудын ахлагч нарыг цуглуулж, их хэмжээний найр хурим хийж байгаад Хятадад Ся гэдэг төр улс шинээр байгуулан өөрөө түүний хаан (ди, ван) болсон тухай албан ёсоор тунхаглан зарласан юм. Эртний Хятадын боол эзэмшигчдийн анхны тэр—Ся улс⁵ тийнхүү бай-

4 Всемирная история, т. I, М., 1955. с. 232-233.

5 Фань Вэнь Лань. Хятадын ерөнхий түүх. I боть, Бээжин, 1978, 29-30-р тал. (хятадаар)

гуулагдаж, түүнийг үндэслэн байгуулагч Ци хаан нь түүхэнд Ся улсын Хоуци ван гэж алдаршсан байна.

Ся улсын нийслэл анхандаа Яньчжай, Юйсянь хотуудад байж байгаад дараа нь Шаньси мужийн баруун урд талын Дася (Их Ся) нутгийн Аньи хотод шилжин төвлөрсөн байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-д Ся улсын түүхийн талаар хийсэн археологийн шинжилгээ,⁶ эртний хятадын нэрт түүхч Сыма Цяний «Түүхийн тэмдэглэл» (МЭӨ I зуун) зэрэг сурвалж баримтаас үзвэл дээр үндэслэсэн иргэншил бий болоод байсан нь тодорхой байна. Ся улсын боолчуудын ихээхэн хэсэг нь урьд адил олзны боолчууд байсан боловч хятад аймгуудын хүмүүс гэмт хэрэг үйлдсэн, алба татвар төлж чадаагүй зэргээс болж бас боол, шивэгчин болох явдал багагүй байв.

Ся улсын үеийн Хятадад боол эзэмших ёсын хэвшил нь нийгмийн хэлбэршил болж эхэлсэн байна. Ся улсын үеэс эхлэн эртний Хятадад боол эзэмших ёс бүрэлдэн тогтох үйл явц идэвхжиж ирсэн ажээ. Гэвч гагцхүү МЭӨ XVII зууны үед түүхийн тавцан дээр гарч ирээд МЭӨ XI зууны үе хүртэл оршин тогтнож байсан Шан (Инь)⁷ улсын үед Хятадад боол эзэмших ёс бүрмөсөн ялж, бүрэн тогтоод нийгмийн хэлбэршил болох үйл явц гүйцэд хэрэгжсэн юм. Шан улсын нийслэл Шан хотын туурийг малтаж археологийн шинжилгээ хийх ажил Хятадад нилээд далайцтай явж ирсэн юм. Түүний үр дүнгээс үзэхэд Шан улсын үед хүрлийн үйлдвэрлэл хүчтэй хөгжиж, боолчуудын тоо олшрон, нийгмийн үйлдвэрлэл, улс орны амьдрал хөгжилд тэд нарын гүйцэтгэх үүрэг холбогдол улам улмаар ихсэж байжээ.

Ся болон ялангуяа Шан улсын үед төр улсын эсрэг боол эзэмшигчдийн эсрэг боолчууд, тариачдын эсэргүүцэл хөдөлгөөн идэвхжиж, ангийн тэмцэл хурцдаж байсан байна. Ся, Шан улсын үеэс эхлэн эртний Хятадад боолчууд, тариачдын бослого хөдөлгөөн удаа дараалан гарч, угсааны төрүүдийн хүчин чадлыг доройтуулан, мөхөх сөнөх явдлыг нь нэг биш удаа шийдвэрлэн түргэтгэж байв. Шан улсын ноёд түшмэд туйлдаа хүртэл ялзарч, төрийн хэрэг эрхэлж чадахаа больсон учир нэг хаан нь өөрийн улсын засгийн газрын тэргүүн ерөнхий сайдаар эрдэм боловсролтой, ухаалаг нэгэн боолыг тохоон томилж, боолчуудын дургүйцэл хилэнгийн галыг намжаан, улсын дотоодыг засах оролдлого хийж байжээ.

Шан улсын үеэс эхлэн Хятадын хаад, ноёд өөрийн улсыг бусдаас ихэд дээгүүр тавьж ертөнцийн төв «Дундад улс» (Чжунго) хэмээн нэрлэж, төрийн тэргүүн хааныг «тэнгэрийн хүвгүүн» гэж алдаршуулах болсон байна. Шан улсын зарим хаад их цэрэг хөдөлгөн гадаад орнуудыг байлдан эзлэх, харь орны ардыг олзлон боолчлох зэрэг түрэмгий гадаад бодлого явуулж байжээ. Жишээлбэл, Шан улсын У Дин ван гэгч нь умар зүгийн Монгол орны өмнөд хэсэг болох Гүйфан зэрэг газар орон дахь хүннү нарын өвөг дээдсийн эсрэг гурван жилийн турш их аян дайн хийж, олон хүн олзлон боол шивэгчин болгож байсан байна. Гэвч Шан улс Гүйфаныг байлдан эзэлж, эрхшээл нөлөөндөө оруулж чадаагүй юм.

МЭӨ XI—МЭӨ III зууны үеийн Хятадад оршин тогтнож байсан эртний Хятадын Чжоу улс, МЭӨ III зууны үеийн Цинь улс нь боол эзэмших ёс нэгэнт бүрэлдэн тогтоод улмаар цаашид гүнзгийрэн хөг-

6 Хятадын ерөнхий түүх, Бээжин, 1981, 27-р тал (хятадаар)

7 Хятадын ерөнхий түүх, Бээжин, 1981, 516-р тал (хятадаар)

жиж байсан үеийн төр улсууд байсан юм. Чжоу улс, Цинь улс хоёрын үеийн хятад оронд хөгжмөл эзэн, боолын ёс ноёлон зонхилж байсан юм.

МЭӨ XI—МЭӨ VIII зууны үед Чжоу улс баруун зүгийн Шэньси мужийн Хаоцзин (Чанань орчим) хотод төвлөн нийслэлж байсан учир тухайн үеийн Чжоу улс нь Баруун Чжоу улс гэж түүхэнд алдаршсан байна. МЭӨ VIII—V зууны үед Чжоу улс зүүн зүгийн Лоян хотод нийслэлэх болж, Ци, Сүн, Лү, Вэй, Цзинь, Чү Юэ, Ү, Цинь гэх зэрэг арав гаруй улс болж хуваагдан байсан⁸ зэрэг учир түүхэнд Зүүн Чжоу улс буюу Цюньцю (хавар намар) хэмээх хэсэг улсын үе гэж нэршжээ. МЭӨ V—III зууны үед Зүүн Чжоу улс нь Цинь, Чү, Ци, Чжао, Янь, Хань, Вэй гэх зэрэг 7 улс болж хуваагдаад өвөр хоорондоо завсар зайгүй дайн дажин болж байсан учир түүнийг Хятадын түүх сударт «байлдааны улсын үе» гэж тэмдэглэн үлдээжээ.

Чжоу улсыг үндэстэн байгуулагчдын анхны гол зарлигууд нь «Хэрэв боол шивэгчин оргон зугтвал түүнийг сайтар эрж заавал олж байвал зохино» гэх зэрэг зүйлийг цохон зааж, боол эзэмших ёсыг бэхжүүлэхэд чиглэгдэж байжээ. Чжоу улсад олзны боолоос гадна олон тооны ялтан, өр ширэнд орогсод, алба татвар төлөх хөрөнгөгүй болсон тариачид, гар урчууд гэмт хэрэгтэн болон улс төрийн хэрэгтэнгүүдийг боол, шивэгчин болгож байжээ. Боол, шивэгчин нар гол төлөв суваг шуудуу татах, далан барих, барилга байгууламж, гар урлал, газар тариалан, мал аж ахуй, гэр зуурын ажилд зүтгэж байв. Мөн цэрэг дайны үйл ажиллагаанд боолчуудыг татан оруулж багагүй ашигладаг байв.

Чжоу улсын ван нь улс орны газар нутгийн дээд өмчтөн эзэн байж, шадар ноёд түшмэд, боол эзэмшигч сурвалжит язгууртан нарт товлосон газрыг түүний дээрхи тариачид, гар урчууд, боолчуудынх нь хамт соёрхол болгож өгч, эзэмшүүлдэг байв. Вангаас газар нутгийн соёрхол хүлээсэн тэдгээр томоохон ноёд, түшмэдийг чжүхоу гэдэг байв. Тэд улс орныг хуваан захирсан их эрх мэдэлтэнгүүд болж байв. Хөршийн хүй нэгдлийн тариачид, гар урчууд хэдийгээр боол биш, жирийн «хар түрүүтэн» гэгдэж байсан боловч нийгэмд эзлэх байр суурь, эрх мэдлийн хувьд боол шивэгчин нараас олон талаар дээрэлхэх юмгүй байв. Чжоу, түүнчлэн мөн Цинь улсын үед ч гэсэн боол эзэмших ёс хараахан үеэ өнгөрөөгөөгүй, эдийн засгийн хөгжилд түлхэц болох талтай байсан ажээ.

Баруун Чжоу улсын үеийн Хятадад хүрлийн үйлдвэрлэл өмнөх үеүдээс мэдэгдэхүйц давуу хөгжиж,⁹ төмөр боловсруулах ажлын эх үүсвэр гарч иржээ. Зүүн Чжоу улсын үед Шар мөрөн, Хуай, Вэй зэрэг томоохон гол уснаас суваг шуудуу татаж, шинэ шинэ атар газрыг зохиомол аргаар усжуулан тариа тарих болсон нь хөдөө аж ахуйд чухал байв. Ялангуяа байлдааны улсын үед Шар мөрөн, Хөх мөрөн, Хуай, Хань зэрэг мөрөн голуудыг холбосон Хүнгоу, Ханьгоу зэрэг томоохон суваг татагдсан нь усан замын тээвэр, худалдаа арилжаа хөгжихөд дөхөм болжээ. Тариалангийн газрыг үе үе хувааж худаглах системээр эзэмшин эдлэх хуучин журмыг халж айл өрх бүрийн амины эзэмшил, оногдол хувийн өмч болгосон нь тариачдын ашиг сонирхлыг дээшлүүлж, газрыг мөн худалдааны гүйлгээнд орж эргэлдэх товаарын шинж чанартай болгосон байна. Тухайн үеийн Хятадын ху-

⁸ Т. В. Степугина. «Китай в первой половине I тысячелетия до н.э.»-в кн. история Древнего мира, Ранняя древность. М., 1982, с. 353-355.

⁹ Owen and Eleanor Lattimore, China, A Short History, New York, 1975, p. 65.

далдаанд нэгэнт алтан зоос цутгаж хэрэглэх болоод байв. Байлдааны улсын үеийн Хятадад төмрийн хүдэр олзворлодог уулын уурхайн тоо 600 гаруй болж үйлдвэрлэлийн багаж, зэр зэвсэг зэргийг нилээд сайн боловсруулсан төмрөөр хийдэг болоод байв.¹⁰ Энэ нь тус орны эдийн засгийн хөгжил, цэрэг дайны хүчин чадлыг зузаатгах зэрэгт дөхөм болж байв. Байлдааны улсын үеийн Хятадын хот, суурингууд нь зөвхөн засаг захиргааны төв төдийгүй, бас гар урлал, худалдааны томоохон төвүүд болж байв. Энэ бүхэн нь тухайн үеийн Хятадад шинжлэх ухааны зарим мэдлэг, түүнчлэн мөн Даосын ёс, Күнзийн сургаал (МЭӨ VI—V зуун) гэх мэтийн гүн ухааны янз бүрийн чиглэл үүсч хөгжих, түүгээр ч барахгүй цаашдаа улс орныг улс төрийн талаар нилээд баттай нэгтгэж, дотоодын нэгдэл нягтралыг бэхжүүлэхийн жинхэнэ бодитой бэлтгэл, материаллаг бааз суурь болж өгсөн байна.

Чухам тийм материаллаг бааз суурь, бодитой бэлтгэл байсны үндсэн дээр эртний Хятадын төвлөн нэгдсэн анхны хүчирхэг эзэнт гүрэн Цинь улс МЭӨ 221 онд байгуулагдсан юм. Үүнээс үзэхэд Мао Цзэдүн, түүний номлолд автсан хятадын зарим түүхчид Цинь улсын үед Хятад орон улс төрийн талаар нэгдсэн зэргийг гагцхүү түүнийг үндэслэн байгуулагч Цинь Шихуанди-гийн гавьяа мэтээр үзэж, түүнийг тэнгэр тултал магтсаар ирсэн нь үзэл онолын хувьд идеалист баримтлал болохын дээр онол-аргазүйн талаар шинжлэх ухаанд харш, хортой завхруулга мөн гэвэл зохино.

Цинь Шихуанди эртний Хятадын байлдааны улсуудын үеийн долоон улсын цэрэг зэвсгийн хүчээр нэгтгэн захирч, эзэнт гүрэн байгуулаад бие урьдах хаадын адил жирийн ван биш дээд эзэн хаан хэмээн тунхагласан юм. Цинь Шихуанди маогийнханы номлодогчлон Хятадуудтай бусад аймаг угсаатныг ойртуулан нягтруулах ажил зохиосонгүй, харин Хятадыг Манж, Монгол, Уйгур, Тангад Төвд мэтийн зэргэлдээх орнуудаас бүрмөсөн тусгаарлан заагласан түмэн газрын урт Цагаан хэрэм бариулж,¹¹ албан ёсны хилийн бэхлэлт шугам болгосон байна. Түүнчлэн мөн аж ахуй, эдийн засгийн ач холбогдолгүй баяр ёслол, албан хэрэгцээний зориулга бүхий асар том, сүрэг ордон хөрш, зам гүүр, булш бунхан барихад олон зуун мянган боолууд, тариачдыг дайчлан зүтгүүлж, үй түмэн хүний амь насыг бусниулан, үлдэгсдийн амьдрал байдлыг тэсэхийн аргагүй болтол эрс доройтуулсан юм. Улсын дотоодод боол, шивэгчний тоо улам олширч, боол эзэмших ёсны дарлал мөлжлөг дээд цэгтээ тултал ширүүссэн байна. Урьд үеийн Хятадын нийгэм-эдийн засаг, соёлын хөгжлөөр бэлтгэгдэж, шинэ бий болсон нэгдмэл байдлын хэрэгцээ шаардлагаар зайлшгүй болж тулгагдан тавигдаад байсан учир Цинь Шихуандийн үед амьдралд хэрэгжсэн зарим зүйл бий. Тухайлбал, улс орон даяар нэгдмэл мөнгөн тэмдэгтэй болсон, нэгдмэл жин хэмжүүр, нэг жилд урт богино, багтаамж талбайн хэмжээ тогтоогдсон юм. Соёлын аймагт нутаг бүрд жигдгүй байсан зураг бичиг, дүрс үсгийг нэг мөр болгон, нилээд хялбарчилж тогтоосон байна. Гэвч улс орон даяар хууль цаазын сурталтны сургаалд тулгуурлан эзэрхэг засаг, хатуу цаазын бодлого явуулж, айл өрх, хүн бүр хамаатан садан, хавь ойрынхныг хариуцан хянах зэрэг харгис дэглэм тогтоосон нь хүн ардыг алхах гишгих газаргүй болтол чандлан захирахад чиглэгдэж байжээ. Энэ бүхэнд боол шивэгчин, жирийн

¹⁰ Owen and Eleanor Lattimore, *China, A Short History*, New York, 1975, p. 65.

¹¹ Цзинь Боцзянь, Шао Сюньчжэн, Хоу Хуа, *Дундад улсын товч түүх*. Бээжин, 1956, 12-13-р тал.

хүмүүс байтугай Күнзийн сурталт эрдэмтэн сэхээтэн нар хүртэл эрс дургүйцэж, ил далд янз бүрээр эсэргүүцэн тэмцжээ. Үүний улмаас Цинь Шихуанди МЭӨ 213 оны үест Күнзийн сургаалын олонхи судар бичгийг хураалган шатаагаад Күнзийн сурталтан олон эрдэмтэн сэхээтнийг баривчлан шоронд хорьж, тэдний дотроос хамгийн нэрд гарсан 460 хүнийг амьдаар нь газарт булж алсан, бусдыг цөмийг хязгаар нутаг, хилийн районд цөлсөн байна.

Цинь Шихуанди, түүнийг залгамжилсан дараагийн эзэн хааны аль аль нь Монгол нутагт оршин амьдарч байсан хүннү, өмнө зүгийн Вьетнам зэрэг зэргэлдээх гадаад аймаг угсаатны хувьд туйлын түрэмгий бодлого явуулж байв. Цинь Шихуанди МЭӨ 215 оны үест Мэн Тянь гэдэг жанжиндаа 300 гаруй мянган цэрэг захируулж, Хүннү нарын эсрэг довтолгон, тэдний ууган нутгийн нэг болох Орос газрыг булаан эзэлсэн байна.

Энэ бүхэн нь Хятад улсын нэгдэл нягтралыг бэхжүүлж, Цинь улсын бат орших явдлыг хангасангүй, харин улсын гадаад, дотоод байдлыг эрс хүндрүүлж, түүний насан хутгийг тун ч ахархан болгосон юм. Үүнд, МЭӨ 209 онд одоогийн Ар, Өвөр Монголын нутаг, Төв Азид нүүдлийн малчин хүннү нарын хүчирхэг гүрэн бий болсон нь Цинь Шихуандийн түрэмгийллийн хариуд Цинь улсад зүй ёсоор дайсагнан, түүний дотоод дахь аливаа бослого хөдөлгөөнд талархалтай хандах болсон байна. Тэр нь Цинь улсад улс төрийн талаар хүчтэй цохилт болсон юм. Мөн Цинь улсын дотор тариачид, боолчуудын том бослого гарч, түүнд Күнзийн сурталтан нар, зарим түшмэд, цэрэг нийлэн нэгдсэн байна. МЭӨ 207 онд Лю Бан тэргүүтэй тариачдын бослогын нэг баг нийслэл хотыг эзлэн авч Цинь улсыг мөхөөсөн байна. Хэрэв Цинь Шихуанди үнэхээр дэвшилттэй хүн байгаад зөв мэргэн бодлого явуулсан бол Хятадын ард түмэн тэгтлээ айхтар дургүйцэж, Цинь улс 15-хан жил болоод тийм амархан мөхөж сөнөх байсан болов уу? Цинь Шихуандийг үхсэний дараа хятадын ард түмэн түүнийг урьд хожид үзэгдээгүй эзэрхэг харгисийн дүнд болгож дүгнэн үнэлсэн явдал санамсаргүй хэрэг биш биз ээ.

Цинь Шихуандийн төрийн бодлого, Цинь улсын хаад ноёдын үйл ажиллагааны үр дагаврын тухай эртний хятадын нэрт сударч Сыма Цянь, Бань Гү нарын зэрэг томоохон түүхчид тус тусын бүтээлдээ цохон тэмдэглэсэн нь «Хан улс засгийн эрхийг авахад Цинь улсаас нэлэнхий эвдрэл сүйтэл уламжлагдан үлдсэн байв. Эд баялгийн зүйл шавхагдан дуусаад...жирийн хүн юу ч үгүй хов хоосон болсон байв»¹², «Хүмүүс хүний мах идэж, тэн хагасаас илүү нь үхэж үрэгдсэн байв» гэсэн байдаг. Хэргийн үнэн байдал тийм байсан учир Цинь Шихуандийн тухай Хятадын ард түмний өгсөн үнэлгээ дүгнэлтийг буруу, Маогийнхыг зөв гэх үндэс огтхон ч үгүй билээ.

МЭӨ 206 оноос МЭ 220 он хүртэл Хятадад Хан улс гэдэг боол эзэмших ёсны хүчирхэг эзэнт гүрэн оршин тогтнож байв. Хан улсын түүхийг Чанань хотод төвлөн нийслэлж байсан Баруун Хан улсын үе (МЭ 25 он хүртэл), Лоян хотод нийслэлж байсан Зүүн Хан улсын үе гэж хоёр хувааж үздэг юм. Хан улсын эхний хаад боол эзэмших ёсыг өргөтгөн бэхжүүлэх чиглэлтэй нилээд арга хэмжээ авсан Хан улсын боолчуудын тоо цөөнгүй байсан боловч боол эзэмших ёс нэгэнт үеэ өнгөрөөсөн нь удалгүй мэдэгдэж, аажимдаа түүнийг хязгаарлах замд орохоос өөр аргагүй болсон юм. Үүний улмаас Хан улсын үе, ялан-

¹² История Китая с древнейших времен до наших дней. М., 1974., с. 37.

гуяа Зүүн Хан улсын үе нь Хятадад боол эзэмших ёс задран мөхөх шат, боол эзэмших ёсны төгсгөлийн үе байв.

Хан улсын хааны ордонд 100 гаруй мянган боол шивэгчин байнга үйлчилж, улсын гар үйлдвэр дээр мөн 100 гаруй мянган боол ажиллаж, сайд түшмэд, газрын эзэд тус бүр хэдэн мянган боолтой, баян чинээлэг боолтой байсан боловч хүн амын дийлэнх нь бас л урьд адил хөршийн хүй нэгдлийн тариачид байв.¹³

Хан улсын үед боол худалдах явдал их дэлгэрч, боол шивэгчнүүдийг үнэ хаялцуулан худалдаалах тусгай зах зээл нээгдэн ажиллаж байжээ. Хүннү, Дорнод Туркестан, Төвд, Вьетнам, Манжуур, Солонгосоос олзлогдсон хэдэн зуун мянган хүнийг орон нутгийн боол шивэгчний хамт цөмийг модон хашаанд мал адил хашиж хорьж байгаад гаргаж худалддаг байжээ. Боол шивэгчнийг харьяат ард, жинхэнэ хүний тоонд оруулахгүй, адгуус мал мэт үзэж, алж хядах, зодож нүдэх урьдын уламжлал хэвээр үлдсэн байв. Гэтэл нөгөө талаас Хятад орны үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн хөгжилд аажмаар шинэ ахиц гарч, боолын хөдөлмөрийг ашиг сонирхолгүй болгож байв. Тухайлбал, Баруун Хан улсын үед Хятадад анх удаа газрын хөрсөн доорхи усыг хоорондоо газар доогуур битүү сувгаар холбогдсон, цуваа олон худаг гаргаж ус татаж хуримтлуулах журмаар ашиглаж тариа тарих болсон нь хөдөө аж ахуйд маш чухал болсон байна. Талбай сэлгэж тариа тариалахын оронд гарзыг өргөөшөө 25 см орчим, уртаашаа алсалсан зурвасуудаар жил дараалан сэлгэж тариалах болсон нь жил бүр их хэмжээний талбай нөөцлөн үлдээхгүй болгож хөдөлмөрийн үр ашгийг нэмэгдүүлжээ. Хөдөө газрын тариаланд төмөр хушуутай, ар талдаа үр цацагчтай шинэ маягийн анжис гаргаж хэрэглээд нийслэлийн орчин тойрны албаны тарианы талбай дээр хос төмөр хушуутай, хоёр үхэр хослуулан хөллөдөг том анжис үйлдэж хэрэглэсэн зэрэг нь тариачдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, боолын хөдөлмөрийг үр ашиг нэн багатай болгосон байна. Энэ бүхний улмаас Хан улсын анхны хаадын үеэс эхлэн зарим боолыг, тухайлбал ял заагдаж боол бологсдыг чөлөөлж, жирийн хараат тариачин болгох зарлиг тушаал гаргахад хүрч байжээ. Баруун Хан улсын оршин тогтнож байсан дунд ба ялангуяа сүүлч үеэр улсын боолын тоог цаашид нэмэгдүүлэхийг зогсоох, «50 ба тавиас дээш насны улсын боолыг чөлөөлж жирийн иргэн болгох», боол эзэмшигчдийн хувийн боолын тоог 200-гаас хэтрүүлэхгүй байлгах тухай хаадын зарлиг удаа дараалан гарч байсан нь санамсаргүй хэрэг биш байв. Ноёлогч ангийн зарим төлөөлөгчид нь боолын эзний зүгээс «Боолчуудыг алж хядах эрхийг хасах» нь аль ч талаар ашигтай болно гэсэн тооцоо гаргаж байв. Энэ нь боолын хөдөлмөр үр ашиггүй болсноос гадна тэдний эсэргүүцэл тэмцэл ихсэж, ангийн тэмцэл сүрхий хурцдаж ирсэнтэй холбоотой юм.

Хан улсын хаад Хүннү зэрэг Төв Азийн нүүдэлчин улс түмний эсрэг түрэмгий бодлого явуулж,¹⁴ дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцохыг оролдож янз бүрээр хутган үймүүлэх, хорлон сүйтгэх явуулга хийж байсан учир нүүдэлчдийн идэвхтэй эсргүүцэлтэй тулгарч, зарим үед өөрсдөө хүнд байдалд орж байжээ.¹⁵ МЭӨ 198 оны үест Баруун Хан улсын анхны эзэн хаан Лю Бан Хүннү гүрний эсрэг хэдэн зуун мянган цэрэг удирдан довтолсон боловч Хүннүгийн Модун (Моодон) шаньюй хааны морин цэрэгт бүслэгдэж, ихээхэн буулт бүхий

¹³ Е. М. Жуков. Очерки методологии истории. М., 1980, с 152.

¹⁴ Owen Lattimore, China, A Short History, New York, 1975, p. 76.

¹⁵ Мөн тэнд.

хэлэлцээр хийж, хатанд нь хээл хахууль өгч байж арай чарай бүслэлтийг тавиулан гарч байжээ. Тэгээд мөн онд Модун, Лю Бан нар тусгай гэрээ байгуулж, Цагаан хэрмээс гаднах Төв Азийн нүүдэлчдийг Хүннүгийн шаньюй захирч, хэрмийн доторх хятадуудыг хятадын хаан мэдэж байх тухай тохиролцож, цагаан хэрмээр хоёр улсын хил хязгаарыг албан ёсоор дахин зааглаж тогтоосон байна.

Дараа нь Баруун Хан улсын Уди хаан МЭӨ 137 оноос эхлэн Хүннү гүрний эсрэг тагнуул төлөөлөгчдөө илгээж, ихэд бэлдэж байгаад МЭӨ 127—119 оны хооронд асар их аян дайн хийсэн боловч тэр нь хятадын ард түмний амьдрал, улс орны дотоод гадаад байдлыг улам хүндрүүлснээс биш, онцын ашиг хонжоотой явдал болсонгүй. Маоист түүхчид Хятадын хувьд тусгаар тогтнон биеэ дасан гадаад улс орны нэг байсан хүннү гүрний эсрэг Хан улсын Уди хааны хийсэн аян дайныг улс орны нэгдлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн чухал үр дүнтэй арга хэмжээ байсан мэт болгож хичнээн шагшин магтавч тэр нь их гүрний жанжлах үзлийн үүднэс түүхийг мушгин гуйвуулахыг оролдсон арчаагүй явуулга болохоос үл хэтрэнэ.

Баруун Хан улсын хаадын дотоод, гадаад бодлогыг хятадын ард түмэн эсэргүүцэж, нэг биш удаа бослого хөдөлгөөн гаргаж байв. МЭ 18—25 оны үест Хятадад «Улаан хөмсөгтний бослого» гэдэг боолчууд, тариачидын том бослого гарч Баруун Хан улсын хаадын ноёрхлыг эцэс болгосон байна.

Зүүн Хан улсын үеийн Хятадад усны хүч ашиглан төмөр хайлуулах хөөрөг ажиллуулах арга нэгээдсэн, ус татах хөөрөг, усан тээрэм зэрэг үйлдвэрлэлийн шин чухал арга хэрэгслүүд гарч ирсэн нь боолын хөдөлмөрийг ерөөс үр ашиггүй болгосон байна. Зүүн Хан улсын үед боол эзэмшигч хуучин сурвалжит язгууртан газрын эздийн хүн нөлөө аажмаар буурч баян «хүчирхэг өрх» айл хэмээх шинэ маягийн газрын эзэд илүү их хүч нөлөөтэй болж байв. Тэдгээр «хүчирхэг өрхийн» эзэмшлийн газар дээр голдуу хөршийн хүй нэгдлийн чөлөөт иргэд байгаад хараат байдалд орсон тариачид, боол байгаад чөлөөлөгдөж мөн хараат тариачин болсон хүмүүс голлон ажиллаж байв. Тийм газрын эздийн аж ахуй нь цаашдаа феодалын маягийн аж ахуй болж, хараат тариачид нь хамжлага харьяат болон хувирах хандлагатай шинэ чухал үзэгдэл болж байв. Тийнхүү Зүүн Хан улсын эзэн, боолын нийгмийн гүнд тухайн үед шинэ, дэвшилттэй, феодалын үйлдвэрлэлийн харилцааны үр хөрөнгө бүрдээд улам улмаар хүчжин бэхжиж байв.¹⁶

МЭ 184 онд Хятад даяар боол эзэмшигчдийн Зүүн Хан улсын төр, хаад ноёдын эсрэг «Шар алчууртны бослого» гэж түүхэнд алдаршсан, боолчууд, тариачид, ядуусын том бослого гарсан байна. Зүүн Хан улсын хаан, сайд түшмэд тэргүүтэй боол эзэмшигчид хичнээн их цэрэг гаргавч бослогыг дарж чадахгүй байв. Ордны түшмэд, тайган нар дэмий л бие биенээ хааны өмнө зэмлэн буруушааж өрсөлдөн шаламгайлахаас биш, бослогыг дарж хүч хүрэхгүй гэдэг нь нийтэд тодорхой болжээ. Тийм нөхцөлд феодалын маягийн шинэ газрын эзэд «хүчирхэг өрхүүд» тус тусын эзэмшлээс амин хувийн цэрэг дайчлан татаж, бослогыг дараад төрийн эрхийг гартаа авахаар шийдсэн байна. «Хүчирхэг өрхийн» хамгийн том төлөөлөгч Цао Цао ноён шинэ газрын эздийн цэргийг толгойлж арав гаруй жил бослогын цэрэгтэй байлдаж

¹⁶ Е. М. Жуков, М. А. Барг, Е. Б. Черняк, В. И. Павлов, Теоретические проблемы всемирно-исторического процесса. М, 1979. с. 173-174. (аргазүйн асуудал).

байгаад 208 оны үед ардын бослогыг туйлын харгис хэрцгий цуслан даржээ. «Шар алчууртны бослого» дарагдсан боловч Зүүн Хан улсын төр мөхөж, боол эзэмших ёс эцэс болох хувь заяаг үндсэнд нь шийдсэн юм. Бослогыг дарсан шинэ газрын эзэд «хүчирхэг өрхийн» цэргийн гол хүчин 220 оны үед Зүүн Хан улсын төрийг мөхөөж, боол эзэмших ёсны ноёрхлыг эцэс болгосон байна. Үүгээр эртний Хятадын түүх дуусч, дундад зууны феодалын Хятадын түүх эхлэх үндэс суурь тийнхүү тавигдсан юм.¹⁷

Тийм учир Хятадад боол эзэмших ёс Шан улсын үед дуусаад Баруун Чжоу улсын үед феодализм бүрмөсөн бүрэлдэн тогтсон байв гэж үзсэн Маогийн номлол, Хятадын эрт, дундад зууны үечлэлийн түүхийн талаар түүний баримталж байсан үзэл түүхэн үнэнд эс нийцэх ажээ.

Гэвч Хятадад боол эзэмших ёс дэлхий дээр хамгийн түрүү эцэс болж, хүн төрөлхтөний түүхэнд Хятад улс, хятадын ард түмэн феодализмын босгыг бусдаас эрт алхсан бодит үнэнийг бид үгүйсгэдэггүй, үнэн мөнөөрийг үздэг юм.

ДРЕВНЕКИТАЙСКОЕ РАБОВЛАДЕЛЬЧЕСКОЕ ГОСУДАРСТВО (XXI до н.э. — III н. э.)

(Резюме)

Н. Ишжамц д. и. н.

В статье дается краткий обзор политической истории древнего Китая, как результат и отражение его общественно-экономического развития.

Констатируя факт появления рабовладельческих обществ и древнейших цивилизаций в Египте, Шумере и Вавилоне, автор считает Китай страной, одной из первых прошедшей через рабовладельческий путь развития и формирование самобытной культуры.

По мнению автора окончательное разложение первобытно-общинного строя и начало возникновения рабовладельческого общества в Китае относится к концу — началу II тысячелетия до н.э., когда там появилось раннеклассовое государственное образование Ся, во многом мало чем отличавшееся от племенных союзов периода «военной демократии». Несмотря на то, что подавляющее большинство населения состояло из сельско-общинного крестьянства, окончательное утверждение рабовладельческих отношений происходит при правлении династии Шан (XVII в. до н. э. — XI в. до н.э.).

Древнекитайское государство Чжоу (XI в. до н.э.—III в. до н.э.) и империю Цинь Шихуана автор считает возможным, отнести к вполне рабовладельческим государствам, подчеркивая в то же время тот факт, что объединение Китая при Цинях явилось результатом сравнительно интенсивного развития страны в предшествующие века, в особенности при Чжаньго (V—III вв. до н.э.). Поэтому,

¹⁷ Степугина Т. В. Китай в первой половине первого тысячелетия. -В кн. «История Древнего мира, упадок древних обществ. М., 1982», с. 146—147.

как отмечает автор, объединение страны нельзя ставить только в заслуги Цинь Шихуана, который, явился виновником беспрецедентных нарушений, крайнего деспотизма и гибели своей династии.

Период правления ханьской династии (III в. до н.э. —III в. н.э.) В статье трактуется как последний этап рабовладения.

В статье особо выделяется роль народных масс и классовой борьбыосновой движущей силы развития общества, а также значение экономических, социальных и других факторов.

Автор подвергает критике маоистские концепции о том, будто Китай являлся чуть ли не единственной страной с самой древней цивилизацией, которая, еще при правлении Чжоу будто стала на путь развитого феодализма. Принципиально осуждая завоевательные походы Цинь Шихуана, Хань Уди и других китайских правителей древности, автор дает отпор маоистской фальсификации истории Монголо-китайских отношений.

В заключение делается вывод о том, что на всем протяжении истории древнего Китая рабы никогда не составляли большинство населения, но тем не менее это государство было рабовладельческим. Китай раньше других перешагнул порог феодализма, но не при династии Чжоу в XI—III вв. н.э., а вскоре после падения ханьской династии-в III в. н.э.